



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

119 /119/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.08.24

ҮЙЛ ЯВДАЛ

БОГДХАН ТӨМӨР ЗАМ ТӨСЛИЙН НЭЭЛТ БОЛЛОО



Богдхан төмөр замын бүтээн байгуулалтын ажлын нээлт өчигдөр боллоо. Тус нээлтийн арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхий сайд Л. Оюун-Эрдэнэ, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, ЗХЖШ-ын орлогч, бригадын генерал Ц.Цогтжаргал нарын бусад албаны хүмүүс оролцоо.

Богдхан төмөр зам нь Рашаант өртөөнөөс Богдхан уулын урдуур тойрч Мааньт өртөөтэй холбогдох бөгөөд Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сумд, Улаанбаатар хотын Багахангай, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн газар нутгийг дамжин

нийт 135.8 км үргэлжлэх 6 зөрлөг, 3 өртөө бүхий бүтээн байгуулалт юм. Мөн 16.6 км 2 туннелийг Монгол Улсад анх удаа бүтээн байгуулж байгаагаараа онцлог бөгөөд цаашдын олон томоохон шийдлийн суурь болох юм.

Ташрамд сонирхуулахад Засгийн газрын хуралдаан 8 дугаар сарын 4-нд болж, Богдхан төмөр замын төслийн суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг "Тавантолгой төмөр зам" ХХК-д олгосон. Богдхан төмөр замын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх "Тавантолгой төмөр зам" нь Монголын анхны төмөр замын инженерийн компани бөгөөд Тавантолгой-Зүүнбаян

чиглэлийн 416,1 км төмөр замын төслийн доод бүтцийн ажилд чанарын хяналт үзүүлэн, төлөвлөгөө, технологи зэрэгт заавар зөвлөгөө өгч ажилласан. Өдгөө Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 1 дүгээр зэрэглэлийн уулзваргүй 240 км төмөр замын амжилттай төслийн ажлыг амжилттай хэрэгжүүлж, 2022 оны 7 дугаар сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Богдхан төмөрзам баригдсанаар Улаанбаатар хотын төмөр зам, авто замын огтлолцолд дунджаар 144 минут зарцуулж байгаа нөхцөл байдал 57 хувиар буурна гэсэн тооцоо бий. Улаанбаатар төмөр замын дагуух

дуу чимээ, тоосжилт, бохирдол эрс багасаж, цаашид бензин, шатах тослох материалын агуулах, нүүрс тээвэрлэлт, хүнсний болон барааны агуулахыг хүн ам төвлөрөн суурьшдаг газраас үе шаттай холдуулах боломж нээгдэх юм.

• Энэхүү төмөр зам баригдсанаар Хөшгийн хөндийн их бүтээн байгуулалт эхэлж, тус хөндийд тээвэр логистикийн гурван шинэ терминал байгуулагдаж, экспорт нэмэгдэж, цаашид эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдах суурь нөхцөл бүрдэж, Төв аймаг цаашид улсын зэрэглэлтэй хот болон тэлэх боломж бүрдэх учиртай.

• Төмөр зам ашиглалтад орсноор дагуул, хаяа хотууд хөгжиж, төрийн болон хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд, гадаадын хөрөнгө оруулагчдын түншлэл идэвхжиж, цаашид Өмнөговь, Орхон, Дархан-Уул, Дорнод, Дорноговь аймаг хотжих үйл явцыг хурдасгасан загвар, сэтгэлгээний болон соёлын өөрчлөлт болж чадах юм.

• Богдхан төмөр зам ашиглалтад орсноор Монгол Улсын нутаг дэвсгэрийг дамжин, хөрш орнууд болон Ази, Европын бүс нутагтай холбох "Эдийн засгийн коридор"-ын хөгжил, түүн дотроо Улаанбаатар төмөр замын тээврийн оролцоо, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд томоохон хувь нэмэр оруулах юм.

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАГ ТАМИРЧИД ГАРААНДАА НЭГДҮГЭЭР БАЙР ЭЗЛЭВ



"Танкийн биатлон 2021" тэмцээнд оролцож байгаа багийн нэгдүгээр экипаж болох Монгол, Венесуэл, Сири, Вьетнам зэрэг улсын танкид өчигдөр нэг гараанд уралдлаа. Монгол Улсын Зэвсэгт хүчний танкийн даргаар дэслэгч М.Зундуйжамц /336/ Танкийн ротын захирагчийн зэвсэглэл техник хариуцсан

орлогчоор танкийн буудагч, хошууч З.Анхбадрах /311/, механик-жолоочоор ахлах ахлагч Д.Дэмидсүрэн /327 / нар уралдаж их буу болон пулемётуудын байнууд болох их бууны 3, НСВТ пулемётын1, ПКТ пулемётын 1-ийг бүрэн устгаж, нийт цаг 23.57 минутын амжилт үзүүлэн гараандаа нэгдүгээр байрыг эзэллээ.

"Танкийн биатлон 2021" тэмцээний нээлт өчигдөр болсон бөгөөд тус ажиллагаанд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, ОХУ-д суугаа Элчин сайдын яамны Цэргийн атташе, хошууч генерал Р.Сүхбат, ЗХЖШ-ын Материал техникийн газрын Зэвсгийн хэлтсийн дарга, хурандаа

П.Чинзориг нар оролцож баг тамирчидтай уулзаж баяр хүргэж амжилт хүссэн юм.

Т а ш р а м д сонирхуулахад "Танкийн биатлон 2021" тэмцээнд 19 улсын баг тамирчид оролцож байгаагаас нэгдүгээр дивизионд 11 улсын 33 экипаж уралдахаас өчигдрийн байдлаар 7 экипаж уралдсан юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
12	4

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.848.0	2.851.0
EUR	3.335.0	3.350.0
CNY	439.0	440.0
RUB	37.50	39.10
JPY	25.55	26.37
KRW	2.35	2.48

ЗУРХАЙ

2021.08.24 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 17/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН ШУВУУН ХОШУУТ ОДТОЙ, ХӨХ ЛУУ ӨДӨ

Үс засуулбал:

Өвчин ирнэ

Наран ургах, шингэх:

05.59-19.50

Барилдлага:

Арвидах

Шүтэн барилдлага:

Сэрэхүй

Суудал:

Үс

Тухайн өдөр хулгана жилтнээ аливаа үйлийгхийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээлавах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтээрийг номхотгох, хөгжмийнзэмсэг урлах, дархны үйлд сайн.

Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюузасуулахад тохиромжгүй.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
196,245 +1560

ЭДГЭРСЭН
180,618 +1566

НАС БАРСАН
902 +4

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
4455 +80

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ
159 +19

ЭДГЭРСЭН
4209 +15

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 213,229,283

Эдгэрсэн

Нийт: 190,804,902

Нас барсан

Нийт: 4,452,278



“ЗАПАД-2021”-ЫН ТУРШУУЛЫН АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ



ОХУ-ын Зэвсэгт хүчний дөрвөн цэргийн тойрог ээлжлэн холбоотон улсуудын хамтарсан стратегийн сургуулийг жил бүр зохион байгуулж эхэлснээс хойш “Центр-2019”, “Кавказ-2020” стратегийн команд штабын сургуулийг амжилттай зохион байгуулж ирсэн.

Харин энэ жил “Запад-2021” стратегийн хамтарсан сургуульд Монгол Улсын Зэвсэгт хүчнийг төлөөлж удирдлагын бүлэг, мотобуудлагын салаа, танкийн салаатайгаар оролцохоор боллоо.

Энэ жил “Холбоотон улсуудын цэргийн аюулгүй байдлыг хангах ашиг сонирхолд цэргийн бүлэглэл (хүч)-ийг ашиглах” нь сэдвийн хүрээнд явагдах бөгөөд тус сургуулийн туршуулын ажиллагаа өнгөрсөн өдрүүдэд

ОХУ-д зохион байгуулагдав. Тус арга хэмжээнд Монгол Улсын Зэвсэгт хүчнийг төлөөлж Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр, Хуурай замын цэргийн артиллерийн дарга, дэд хурандаа С.Ганбаяр, Хуурай замын цэргийн Цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн сэтгэл зүйн хангалтын офицер, ахмад Ц.Ганбат, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагчийн I орлогч, штабын дарга, дэд хурандаа Э.Билэгсайхан нарын бүрэлдэхүүн оролцлоо. Энэ үеэр хамтарсан стратегийн сургуульд оролцох протоколд Монгол Улсын Зэвсэгт хүчнийг төлөөлж бригадын генерал Л.Онцгойбаяр гарын үсэг зурснаар хоёрдахь туршуулын ажиллагаа дуусгавар болсон

юм. Түүнчлэн энэ удаагийн сургуулийн хоёр дахь газар орны туршуулаар Монгол, Армени, Энэтхэг, Беларусь улсын Зэвсэгт хүчний алба хаагчид оролцлоо.

“Запад-2021” стратегийн хамтарсан сургууль нь ОХУ-ын Зэвсэгт хүчний баруун цэргийн тойргийн “Мулино” сургалтын төвд 2021 оны 9 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулагдах бөгөөд энэ талаар сургуулийн ерөнхий цагийн байдлыг ОХУ-ын Зэвсэгт хүчний байдлааны бэлтгэлийн удирдлагын төвийн дарга, хурандаа генерал И.А. Бувальцев танилцуулав. “Запад-2021” хамтарсан стратегийн сургуулийн онцлог нь аливаа улс оронд аюул занал учирсан тохиолдолд холбоотон улсууд хамтарсан цэргийн хүчээр хэрхэн даван гарах ач холбогдолтой юм.



ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ БЭЛТГЭЛ СУРГАЛТ ЯВАГДАВ



Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, цэргийн штабын 2021 оны цэргийн сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдтэй “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл” сургалтыг Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн материаллаг баазыг түшиглэн оны 8 дугаар сарын 6-ны өдрөөс 10 хоногийн

хугацаатай зохион байгууллаа. Тус сургалтад хамрагдаж байгаа иргэдэд Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын “Сургалтын хөтөлбөр, мэдээний маягт батлах тухай” тушаалд заагдсан хичээлүүдээр сургалтыг явуулан Батлан хамгаалах хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмүүд, зөвсэг, техникийн бэлтгэл, цэргийн инженерийн бэлтгэлийн талаар ерөнхий ойлголт өгч, онолоор орсон сургалтыг дадлагаар баталгаажуулан

цэргийн хэргийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаа. “Covid-19” цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан халдвар хамгааллын дэглэмийг чанд сахин, хүн нэг бүрээр түргэвчилсэн шинжилгээ өгүүлж халдвараас сэргийлэн аюулгүй байдлыг хангасан. Сургалтын явцад цэргийн штабын сургалтын төв байгуулах талбайг тэгшлэх, суурийг ухаж тэмдэглээ хийх зэрэг ажлыг давхар хийж гүйцэтгэлээ. Дэд хурандаа Ч.ДАМДИНСҮРЭН

МОНГОЛ УЛС, БНСУ-ЫН ХАМТАРСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн БНСУ-ын Батлан хамгаалах дүн шинжилгээний хүрээлэнтэй хамтран хоёр талын хамтарсан эрдэм шинжилгээний хурлыг энэ сарын 20-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгууллаа. Энэ удаагийн хурлыг “Ковид-19 цар тахал ба БНСУ-Монгол Улсын харилцаа” сэдвээр зохион байгуулсан бөгөөд хуралд Монгол Улсын талаас ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээний, нийгмийн түншлэл хариуцсан дэд захирал, шинжлэх ухааны доктор, хурандаа Т.Соронзонболд, тус хүрээлэнгийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн дарга, доктор, хурандаа Б.Эрдэнэчимэг, мөн хуралдаа Т.Соронзонболд, тус хүрээлэнгийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн дарга, доктор, хурандаа Б.Эрдэнэчимэг тэргүүтэй эрдэмтэн, судлаач нар болон Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яамны цэргийн атташе, дэд хурандаа Э.Түшиг оролцлоо.

Хурлыг нээж БНСУ-ын Батлан хамгаалах дүн шинжилгээний хүрээлэнгийн ерөнхийлөгч Ким Юнь Тэ, Монгол Улсын Үндэсний Батлан

хамгаалах их сургуулийн Эрдэм шинжилгээний, нийгмийн түншлэл хариуцсан дэд захирал, шинжлэх ухааны доктор, хурандаа Б.Өлзийхуяг нар үг хэлсэн. Хурал үндсэн хоёр хэсгээс бүрдсэн бөгөөд эхний хэсэгт цар тахлын үед тулгамдаж буй аюул, эрсдэл, цар тахалтай тэмцэхэд хоёр улсын Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний гүйцэтгэж буй үүргийн талаар илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлээ. Эхний хэсгийг БХЭШХ-ийн дэд захирал, доктор, хурандаа Т.Соронзонболд даргалж, Монгол Улсын талаас БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн дарга, доктор, хурандаа Б.Эрдэнэчимэг, мөн хуралдаа Т.Соронзонболд, тус хүрээлэнгийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн дарга, доктор, хурандаа Б.Эрдэнэчимэг тэргүүтэй эрдэмтэн, судлаач нар болон БНСУ-ын талаас БХДШХ-ийн Аюулгүй байдал, стратегийн төвийн судлаач Пак Сан Хён нар илтгэл хэлэлцүүлээ. Хурлын хоёрдугаар хэсэгт хоёр талын удирдлагууд цаашид хамтын ажиллагаагаа хэрхэн хөгжүүлэх талаар хэлэлцсэн. Энэ үеэр цаашид хоёр

хүрээлэн 2012 онд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичигтээ тулгуурлан харилцаагаа улам идэвхтэй хөгжүүлэх, санамж бичгийн зарим заалтыг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарах, хамтарсан төсөл, судалгаа хэрэгжүүлэх чиглэлд анхаарч ажиллахаар тохиролцлоо.

Түүнчлэн БНСУ-ын Батлан хамгаалах дүн шинжилгээний судлаач нар энэ оны 10 дугаар сард Монгол Улсын Батлан хамгаалах яамны 110 жил, ҮБХИС-ийн 100 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулагдах “Зүүн хойд Азийн аюулгүй байдал: Итгэлцлийг бэхжүүлэх нь” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцох сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. Ташрамд дурдахад, хоёр хүрээлэнгийн хамтын ажиллагаа 2008 оноос хойш идэвхтэй хөгжиж байгаа бөгөөд энэ удаагийн эрдэм шинжилгээний хурал 11 дэх удаагийн хамтарсан хурал юм. Урьд өмнөх хурлууд Монгол Улс болон БНСУ-д ээлжлэн зохион байгуулагдаж байсан ч энэ онд цар тахлаас үүдэн анх удаа цахимаар зохион байгуулагдсан билээ.

ЦЭРГИЙН АЖИГЛАГЧ ОФИЦЕР, СЕКТОР КОМАНДЛАГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2021-2022 онд үүрэг гүйцэтгэх цэргийн ажиглагч офицер, сектор командлагчийн сонгон шалгаруулалтыг 2021 оны 9 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид

2021 онд шинээр батлагдсан “ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ” –тай танилцаж, НҮБ-ын цэргийн

ажиглагч, штабын ажилтанд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ. Үүнд:

1. Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
2. Ажил байдлын тодорхойлолт;
3. Жолооны үнэмлэхийн хуулбар;
4. Цэргийн ажиглагч,

штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар;

5. Сүүлийн 3 сарын дотор авхуулсан 4x6 хэмжээтэй цээж зураг 2 хувь;

6. Товч судалгаа;

7. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт.

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг АУГ-ын ЭДАХ-ийн psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3203, 92115982, 92096622/-тэй холбогдож тодруулж болно.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын төв штабт дараах ажлын байранд үүрэг гүйцэтгэх (P-3, P-4, P-5) сонирхолтой офицеруудын сонгон шалгаруулалтыг 2021 оны 9 дүгээр сарын 1-3-ны өдрүүдэд зохион байгуулна. Үүнд:

Сургалтын офицер P-4 Дүн шинжилгээний офицер P-3 Сургалтын офицер P-3 Дүн шинжилгээний офицер P-4 Энхийг сахиулах ажиллагаа хариуцсан офицер P-4

Төлөвлөлтийн офицер P-4 (Хүний нөөц, бодлого төлөвлөлт)

Холбогч офицер P-4 Цэргийн зөвлөхийн туслах P-5

Ахлах холбогч офицер P-5 С о н г о н шалгаруулалтад хамрагдах хүсэлтэй цэргийн алба хаагчид

2021 онд шинээр батлагдсан “ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ”

–ыг судлан танилцаж, НҮБ-ын штабын ажилтанд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор харьяа командлал, газар, хэлтсээр дамжуулан саналаа ирүүлнэ. Холбогдох албан тушаалын жагсаалт тавигдах шаардлага, дэлгэрэнгүй мэдээллийг psod@mil.gov.mn цахим мэйл хаягаар болон 3203, 92115982, 92096622 утсаар холбогдож тодруулж болно.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ

Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС

“Соёмбо” сонин

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхтэй, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)